

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер В.Эрдэнэцогт Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор М.Пагамдулам Утас: 261205 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Дундманхайдай Аудит ХХК Захирал: Ж.Бямбажав Утас: 99085151 Цахим хаяг: byambaahunnu@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	0
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/411
танай _____-ны № _____-т

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБОЛД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 733.116.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй 619.765.0 мянган төгрөгийн оношлуур агуулахад биетээр байхгүй, бэлтгэн нийлүүлэгчээс хүлээж аваагүй;
- Улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 11,542.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон;
- Бүтэц орон тоонд байхгүй албан тушаалд хавсран ажилласны нэмэгдэлд 2,564.8 мянган төгрөгийг тооцож олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 23 дугаар зүйлийн 23.2 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд цээжний хөндийн дурангийн мэс заслын хагалгаа 22, хэвлийн дурангийн мэс заслын хагалгаа 2, уушгины дурангаар мэс заслын хагалгаа 28, нурууны ясны титан бэхэлгээт мэс заслын хагалгааг 19 хүнд хийхэд төсвөөс, нийт 4,679,058.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл зарцуулсан бөгөөд өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/495 дугаар тушаалаар тус төвийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг, дурангийн кабинетын засварын санхүүжилтэд 495,566.5 мянган төгрөг, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн тусламжаар хүүхдийн тасгийг шинээр байгуулахад зориулж 240,200.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосны дагуу урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэн бүрэн ашиглалтад оруулсан байна.

Бусад асуудал

Тус төв нь Монгол Улсын эмнэл зүйн оношилгооны практикт гепатит В вирусийн бүрэн геномын NGS технологи буюу бүрэн геномын дараалал тогтоох шинжилгээг Монгол Улсад анх удаа нэвтрүүлснээр гепатит В вирусийн эмийн тэсвэрлэлтийг тодорхойлох, вирусийн тархалт, хоруу чанар болон генетикийн өөрчлөлтийг тодорхойлох, хянах боломжийг бүрдүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,077,880,634.28	42,777,214,659.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,934,407,638.51	1,119,055,324.22
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	2,934,407,638.51	1,117,697,124.22
31210	Төгрөг	2,812,282,447.68	1,117,697,124.22
31211	Төрийн сангийн харилцах	2,812,282,447.68	1,117,697,124.22
31220	Гадаад валют	122,125,190.83	-
31221	Төрийн сангийн харилцах	122,125,190.83	-
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	-	1,358,200.00
33	АВЛАГА	3,001,632,251.84	2,073,955,837.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	369,355.55	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	358,298,066.29	2,073,955,837.90
33500	Бусад авлага	2,642,964,830.00	-
33510	Байгууллагаас авах авлага	2,642,964,830.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	33,141,840,743.93	39,584,203,497.46
35100	Түүхий эд материал	30,830,394,545.95	38,211,732,326.97
35110	Тусгай зориулалттай материал	3,567,384,959.32	3,725,680,554.45
35130	Эм боох материал	27,263,009,586.63	34,486,051,772.52
35400	Хангамжийн материал	2,311,446,197.98	1,372,471,170.49
35410	Бичиг хэргийн материал	63,663,190.00	38,781,600.00
35420	Аж ахуйн материал	149,717,333.51	148,026,187.41
35430	Сэлбэг хэрэгсэл	33,633,085.00	37,235,385.00
35440	Түлш, шатах тослох материал	11,978,321.90	4,352,445.80
35460	Хүнсний материал	27,261,141.00	38,349,820.00
35470	Бусад хангамжийн материал	2,025,193,126.57	1,105,725,732.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	55,094,779,664.18	51,120,873,513.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	55,094,779,664.18	51,120,873,513.05
39200	Биет хөрөнгө	52,392,999,731.81	48,420,100,933.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	41,718,496,136.19	42,224,442,658.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,307,263,638.18)	(8,626,172,258.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,685,728,114.85	3,323,353,145.56
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,506,811,997.25)	(1,880,992,455.65)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,442,818,611.56	36,358,750,516.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,652,583,248.29)	(23,899,604,262.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,100,985,120.45	2,140,791,276.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,204,638,809.73)	(1,310,775,023.88)
39209	Зам, гүүрний байгууламж	67,476,323.48	67,476,323.48
39210	Хуримтлагдсан элэгдэл	(33,360,002.82)	(38,919,988.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,912,280.00	145,652,880.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(58,759,158.45)	(83,901,878.49)
39300	Биет бус хөрөнгө	2,701,779,932.37	2,700,772,579.93
39301	Программ хангамж	164,129,750.00	177,199,020.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(149,436,497.63)	(163,513,120.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,687,086,680.00	2,687,086,680.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	94,172,660,298.46	93,898,088,172.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,402,159,955.55	11,512,937,972.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,402,159,955.55	11,512,937,972.22
41300	Өглөг	11,280,034,764.72	11,512,937,972.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	126,109,524.47	2,872,604,000.34
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,111,651,226.25	8,640,333,971.88
41360	Бусад өглөг	42,274,014.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	42,274,014.00	-

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41400	Урьдчилж орсон орлого	122,125,190.83	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	122,125,190.83	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	82,770,500,342.91	82,385,150,200.41
51	Засгийн газрын хувь оролцоо	82,770,500,342.91	82,385,150,200.41
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,296,448,769.60	20,296,448,769.60
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	20,296,448,769.60	20,296,448,769.60
51200	Хуримтлагдсан үр дүн	28,412,893,061.23	28,127,974,538.63
51210	Өмнөх үеийн үр дүн	103,489,045,490.38	28,513,324,681.13
51220	Тайлант үеийн үр дүн	(75,076,152,429.15)	(385,350,142.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,061,158,512.08	33,960,726,892.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=+	94,172,660,298.46	93,898,088,172.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	60,863,636,235.56	89,886,225,819.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,773,873,246.44	89,886,225,819.18
120	Нийтлэг татварын бус орлого	41,773,873,246.44	66,342,063,218.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,467,284,218.70	29,172,460,153.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,175,210,209.00	1,405,739,778.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,292,074,009.70	27,766,720,374.87
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,116,051,778.43	1,397,986,175.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	17,190,537,249.31	35,771,616,889.82
122	Тусламжийн орлого	-	23,544,162,601.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	23,544,162,601.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	23,544,162,601.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	23,544,162,601.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,089,762,989.12	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,089,762,989.12	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,089,762,989.12	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	116,035,507,480.27	64,856,684,781.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,035,507,480.27	64,856,684,781.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,290,658,756.38	63,606,723,454.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,545,918,978.75	29,386,235,091.58
210101	Үндсэн цалин	11,673,297,508.53	13,475,639,490.52
210102	Нэмэгдэл	10,676,917,711.75	12,312,390,889.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	675,604,178.00	843,065,000.00
210104	Урамшуулал	2,520,099,580.47	2,755,139,711.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,158,789,153.04	3,549,052,311.43
210201	Тэтгэврийн даатгалын зардал	2,105,112,890.18	2,378,297,855.68
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	250,996,619.10	286,210,113.41
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	237,163,893.65	214,182,310.27
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	91,922,327.98	133,506,331.96
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	473,593,422.13	536,855,700.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,768,298,425.06	2,044,412,126.65
210301	Гэрэл, цахилгаан	755,421,239.65	915,537,486.60
210302	Түлш, халаалт	491,701,137.23	450,555,914.76
210303	Цэвэр, бохир ус	521,176,048.18	678,318,725.29
2104	Хангамж, бараа материалын зардал	60,186,647,551.87	974,369,059.08
210401	Бичиг хэрэг	118,687,248.00	176,025,009.66
210402	Тээвэр, шатахуун	565,517,339.57	524,145,059.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,206,823.22	54,176,861.72

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	2,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,181,308.95	48,229,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,702,145.03	170,964,720.70
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,960,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	59,122,392,687.10	828,007.90
2105	Нормативд зардал	15,294,668,508.92	17,627,858,518.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,874,819,152.72	15,974,033,426.55
210502	Хоол, хүнс	1,408,334,518.70	1,632,182,922.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,514,837.50	21,642,170.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	616,505,292.00	147,383,480.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	521,040,880.00	24,914,640.55
210602	Тавилга	2,000,000.00	-
210604	Урсгал засвар	93,464,412.00	122,468,840.00
2107	Томилолт, зочны зардал	698,675,850.00	929,147,778.00
210701	Гадаад албан томилолт	14,999,871.00	69,752,302.00
210702	Дотоод албан томилолт	683,675,979.00	859,395,476.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,137,925,801.52	1,689,552,704.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,074,130,339.52	1,635,165,667.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,000,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,804,815.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,250,948.00	9,441,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	469,755.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	-
210807	Газрын төлбөр	27,074,014.00	17,422,295.15
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,075,930.00	8,692,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,883,229,195.22	7,258,712,384.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,568,237.00	207,530,219.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорог	5,876,660,958.22	7,051,182,165.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	744,848,723.89	1,249,961,326.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	744,848,723.89	1,249,961,326.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	727,618,723.89	1,223,217,326.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,230,000.00	26,744,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(55,171,871,244.71)	25,029,541,037.39
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,904,281,184.44	25,414,891,179.89
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	19,895,593,088.74	25,414,497,846.56
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	8,688,095.70	393,333.33
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(19,904,281,184.44)	(25,414,891,179.89)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(75,076,152,429.15)	(385,350,142.50)

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	44,090,930,458.28	50,878,839,791.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,589,409,409.53	50,878,839,791.59
120	Нийтлэг татварын бус орлого	23,589,409,409.53	29,050,334,962.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,467,284,218.70	29,050,334,962.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,175,210,209.00	1,405,739,778.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,292,074,009.70	27,644,595,184.04
120009	Бусад орлого	122,125,190.83	-
122	Тусламжийн орлого	-	21,828,504,829.39
1221	Хандив тусламж /дотоод/	-	21,828,504,829.39
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	21,828,504,829.39
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	21,828,504,829.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,501,521,048.75	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,501,521,048.75	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,501,521,048.75	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,630,302,619.09	51,014,508,933.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,630,302,619.09	51,014,508,933.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,885,453,895.20	49,764,547,606.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,606,293,768.44	25,460,246,939.35
210101	Үндсэн цалин	12,646,900,381.35	11,763,582,675.12
210102	Нэмэгдэл	10,489,902,559.83	11,079,791,341.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	341,720,607.83	731,226,918.50
210104	Урамшуулал	2,127,770,219.43	1,885,646,004.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,011,319,600.00	4,732,914,632.21
210201	Тэтгэврийн даатгалын зардал	2,334,470,400.00	3,688,238,882.21
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	169,211,800.00	216,298,133.33
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	84,606,400.00	296,836,050.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	84,606,400.00	98,945,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	338,424,600.00	432,596,266.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,768,298,425.06	2,044,412,126.65
210301	Гэрэл, цахилгаан	755,421,239.65	915,537,486.60
210302	Түлш, халаалт	491,701,137.23	450,555,914.76
210303	Цэвэр, бохир ус	521,176,048.18	678,318,725.29
2104	Хангамж, бараа материалын зардал	1,017,967,892.57	940,201,881.63
210401	Бичиг хэрэг	151,022,269.00	127,709,659.66
210402	Тээвэр, шатахуун	565,610,901.47	522,576,299.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,389,987.22	55,385,861.72
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	172,563,725.25	102,852,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93,381,009.63	131,677,461.25
2105	Нормативд зардал	13,393,810,767.87	13,475,025,418.19

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,022,757,155.87	11,813,147,432.19
210502	Хоол, хүнс	1,352,387,212.00	1,646,668,586.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,666,400.00	15,209,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,324,702.00	220,350,516.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,670,000.00	88,568,320.00
210602	Тавилга	7,452,528.00	-
210604	Урсгал засвар	91,202,174.00	131,782,196.00
2107	Томилолт, зочны зардал	703,647,330.00	924,395,002.00
210701	Гадаад албан томилолт	14,999,871.00	69,752,302.00
210702	Дотоод албан томилолт	688,647,459.00	854,642,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,194,171,395.26	1,767,525,871.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,157,177,577.26	1,713,618,898.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,000,000.00	13,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,804,815.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,250,948.00	1,476,973.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	469,755.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	-
210807	Газрын төлбөр	-	27,100,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,348,300.00	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,620,014.00	199,475,219.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,620,014.00	199,475,219.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	744,848,723.89	1,249,961,326.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	744,848,723.89	1,249,961,326.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	727,618,723.89	1,223,217,326.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,230,000.00	26,744,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(4,539,372,160.81)	(135,669,142.29)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,831,125,599.98	1,679,683,172.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,831,125,599.98	1,679,683,172.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,831,125,599.98	1,679,683,172.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,831,125,599.98	1,679,683,172.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,831,125,599.98)	(1,679,683,172.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(6,370,497,760.79)	(1,815,352,314.29)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,304,905,399.30	2,934,407,638.51
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,934,407,638.51	1,119,055,324.22

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,296,448,769.60	34,078,317,488.71	103,489,045,490.38	157,863,811,748.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(17,158,976.63)		(17,158,976.63)
Тайлант үеийн үр дүн	-	-	(75,076,152,429.15)	(75,076,152,429.15)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,296,448,769.60	34,061,158,512.08	28,412,893,061.23	82,770,500,342.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	100,431,619.90	100,431,619.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	100,431,619.90	100,431,619.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(100,431,619.90)	-	(100,431,619.90)
Тайлант үеийн үр дүн	-	-	(385,350,142.50)	(385,350,142.50)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,296,448,769.60	33,960,726,892.18	28,127,974,538.63	82,385,150,200.41

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	57,696,062,500.00	50,999,606,782.42	6,696,455,717.58	88.4
12	Татварын бус орлого	57,696,062,500.00	50,999,606,782.42	6,696,455,717.58	88.4
120	Нийтлэг татварын бус орлого	37,273,503,000.00	29,171,101,953.03	8,102,401,046.97	78.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,910,195,000.00	1,404,381,578.16	505,813,421.84	73.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	35,363,308,000.00	27,766,720,374.87	7,596,587,625.13	78.5
122	Тусламжийн орлого	20,422,559,500.00	21,828,504,829.39	(1,405,945,329.39)	106.9
122001	Хандив тусламж /дотоод/	20,422,559,500.00	21,828,504,829.39	(1,405,945,329.39)	106.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,508,345,300.00	52,694,192,105.88	7,814,153,194.12	87.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,508,345,300.00	52,694,192,105.88	7,814,153,194.12	87.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,025,542,400.00	51,444,230,778.92	7,581,311,621.08	87.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,587,505,000.00	25,460,246,939.35	1,127,258,060.65	95.8
210101	Үндсэн цалин	17,431,940,100.00	11,763,582,675.12	5,668,357,424.88	67.5
210102	Нэмэгдэл	5,437,556,800.00	11,079,791,341.42	(5,642,234,541.42)	203.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	812,400,000.00	731,226,918.50	81,173,081.50	90.0
210104	Урамшуулал	2,905,608,100.00	1,885,646,004.31	1,019,962,095.69	64.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,409,517,400.00	4,732,914,632.21	676,602,767.79	87.5
210201	Тэтгэврийн даатгал	4,073,580,400.00	3,688,238,882.21	385,341,517.79	90.5
210202	Тэтгэмжийн даатгал	267,187,400.00	216,298,133.33	50,889,266.67	81.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	400,781,100.00	296,836,050.00	103,945,050.00	74.1
210204	Ажилгүйдлийн даатгал	133,593,700.00	98,945,300.00	34,648,400.00	74.1
210205	Эрүүл мэндийн даатгал	534,374,800.00	432,596,266.67	101,778,533.33	81.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,630,464,400.00	2,044,412,126.65	586,052,273.35	77.7
210301	Гэрэл, цахилгаан	1,084,104,400.00	915,537,486.60	168,566,913.40	84.5
210302	Түлш, халаалт	713,487,300.00	450,555,914.76	262,931,385.24	63.1
210303	Цэвэр, бохир ус	832,872,700.00	678,318,725.29	154,553,974.71	81.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,292,715,300.00	958,567,931.63	334,147,368.37	74.2
210401	Бичиг хэрэг	163,198,700.00	127,709,659.66	35,489,040.34	78.3
210402	Тээвэр, шатахуун	789,881,900.00	522,576,299.00	267,305,601.00	66.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	84,999,000.00	55,385,861.72	29,613,138.28	65.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	103,400,000.00	102,852,600.00	547,400.00	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	151,235,700.00	150,043,511.25	1,192,188.75	99.2
2105	Нормативд зардал	15,958,441,800.00	13,475,025,418.19	2,483,416,381.81	84.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,155,890,000.00	11,813,147,432.19	2,342,742,567.81	83.5
210502	Хоол, хүнс	1,787,551,800.00	1,646,668,586.00	140,883,214.00	92.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,000,000.00	15,209,400.00	(209,400.00)	101.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,352,902,300.00	1,831,777,038.00	1,521,125,262.00	54.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,372,374,900.00	1,172,485,820.00	199,889,080.00	85.4

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,980,527,400.00	659,291,218.00	1,321,236,182.00	33.3
2107	Томилолт, зочны зардал	1,420,687,700.00	924,395,002.00	496,292,698.00	65.1
210701	Гадаад албан томилолт	70,000,000.00	69,752,302.00	247,698.00	99.6
210702	Дотоод албан томилолт	1,350,687,700.00	854,642,700.00	496,045,000.00	63.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,131,277,900.00	1,808,366,471.47	322,911,428.53	84.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,066,705,900.00	1,752,959,498.47	313,746,401.53	84.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	13,000,000.00	3,500,000.00	78.8
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,310,000.00	1,476,973.00	833,027.00	63.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	495,000.00	330,000.00	165,000.00	66.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,167,000.00	1,500,000.00	4,667,000.00	24.3
210807	Газрын төлбөр	27,100,000.00	27,100,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,030,600.00	208,525,219.42	33,505,380.58	86.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	242,030,600.00	208,525,219.42	33,505,380.58	86.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,482,802,900.00	1,249,961,326.96	232,841,573.04	84.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,482,802,900.00	1,249,961,326.96	232,841,573.04	84.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,421,158,900.00	1,223,217,326.96	197,941,573.04	86.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,644,000.00	26,744,000.00	34,900,000.00	43.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(2,812,282,800.00)	(1,694,585,323.46)	(1,117,697,476.54)	60.3
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,812,282,800.00	1,694,585,323.46	1,117,697,476.54	60.3
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,812,282,800.00	1,694,585,323.46	1,117,697,476.54	60.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,812,282,447.68		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,117,697,124.22		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,346.00	82,020.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	800	728	72	91.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	707	638	69	90.2
620003	Үйлчлэх ажилтан	61	58	3	95.1
620004	Гэрээт ажилтан	28	28	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь байгууллагын алсын харааг “Халдварт өвчнийг сөрөн тэсвэрлэх чадвартай Монгол Улсыг цогцлоох” эрхэм зорилтыг “Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэн, халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, хүний нөөцийн тогтвортой хөгжил, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангана” гэж тодорхойлжээ.

Тус төв нь улсын хэмжээнд халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, халдварт өвчний чиглэлээр лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр ханган үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, заавар, журам, шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Монгол улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт;
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт;
- ЭМС-ын 2025 оны А/173 дугаар тушаалаар “Аюултай хог хаягдал тээвэрлэн боловсруулах, устгах журам” шинэчлэн баталсан;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2023 оны А/118 тоот тушаалаар "Төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг шинэчлэн боловсруулсан.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус төвийн ажилтнуудын нэмэгдэл хөлс олголтод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн бөгөөд 2025 оны эхний 7 дугаар сард ажилтнуудад олгосон нэмэгдэл хөлстэй холбоотой, нийт 117,881.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд санхүүгийн ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлнэ гэсэн дүгнэлт гарсан бөгөөд хэрэгжилт хангалтгүй, зөрчил арилаагүй байна.

Тус төвийн орон тоо бүтцээр орон тооны дотоод аудитортой байхаар баталсан боловч эхний 10 сард аудитор томилогдоогүй тул тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн даргын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 274,572.1 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,934,407.6	1,119,055.3	(1,815,352.3)
Авлага	3,001,632.3	2,073,955.8	(927,676.4)
Бараа материал	33,141,840.7	39,584,203.5	6,442,362.8
Үндсэн хөрөнгө	55,094,779.7	51,120,873.5	(3,973,906.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	94,172,660.3	93,898,088.2	(274,572.1)
Өр төлбөр	11,402,160.0	11,512,938.0	110,778.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	82,770,500.3	82,385,150.2	(385,350.1)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	94,172,660.3	93,898,088.2	(274,572.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,119,055.3 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 1,815,352.3 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдлээс үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 2,073,955.8 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 927,676.4 мянган төгрөгөөр буурахад Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 2,073,955.8 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 1,727,915.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 4,729,548.0 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сан болон бусад байгууллагуудаас авах авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 39,584,203.5 мянган төгрөгт хүрч 6,442,362.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 13,637,234.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлсэн багаж хэрэгсэл болон хангамжийн материал 32,623,284.8 мянган төгрөг, хандиваар 316,370.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан авсан 2,831,961.4 мянган төгрөг, данс хооронд шилжүүлсэн 15,350.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 15,646,840.6 мянган төгрөг, данс хооронд шилжүүлсэн 1,928,760.5 мянган төгрөг, эмнэлгийн байгууллагуудад шилжүүлсэн багаж хэрэгсэл болон хангамжийн материал 25,406,238.2 мянган төгрөгөөр тус тус хасагдсан нь голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 51,120,873.5 мянган төгрөгт хүрч 3,973,906.2 мянган төгрөгөөр буурахад худалдан авсан 1,679,683.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө 592,905.7 мянган төгрөг, гадаадын болон дотоодын аж ахуй нэгж байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 805,080.4 мянган төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгө 65,000.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 92 дугаар тогтоолын дагуу балансаас баланст шилжүүлсэн 59,466.0 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 762 дугаар тогтоолоор акталсан 966,083.8 мянган төгрөг, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 6,091,025.6 мянган төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,512,938.0 мянган төгрөг болж 110,778.0 мянган төгрөгөөр нэмэгдэхэд эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад төлөх 8,640,333.9 мянган төгрөг, татварт төлөх 1,827,365.1 мянган төгрөг, нийгмийн даатгалд төлөх 1,045,238.9 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 82,385,150.2 мянган төгрөг болж 385,350.1 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Байгууллагын үйл ажиллагаанд нийт 177,929.7 мянган төгрөгийн 32 ширхэг программ хангамжийг ашигладаг бөгөөд тайлант онд систем хөгжүүлэлт, лицензийн төлбөрт 4,740.6 мянган төгрөгийг төлсөн байна. Тухайлбал: Улаан бурхан болон томуугүйг танталд судалгааны тайлангийн хянах самбарын программын 1 жилийн эрхийн /Tableau Creator/-д лицензийн төлбөрт 3,950.1 мянган төгрөг, /Tableau Viewer/-д лицензийн төлбөрт 790.5 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 25,894,023.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,324,196.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 24,281,432.7 мянган төгрөг, нийт 51,499,652.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 5,435,518.6 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 46,064,133.6 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 20,101,760.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 25,962,373.6 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоо мэдээг үндэслэн судалгаа, тооцоолол хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Тодотголоор зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,444,211.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 60,508,345.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 20,422,599.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 40,085,785.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын, тусламж үйлчилгээний санхүүжилтээс 21,828,504.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,405,381.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 27,766,720.4 мянган төгрөг, нийт 50,999,606.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 52,694,192.1 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 588,052.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 334,147,368.7 мянган төгрөг, норматив зардлыг 2,483,416.4 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 1,521,125.3 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 496,292.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 589,258.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	60,508,345.3	52,694,192.1	7,814,153.2	87.1
1.1	80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал	22,003,435.9	20,656,579.6	1,346,856.3	93.9
1.2	80802- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,644.0	26,744.0	34,900.0	43.4
1.3	81614-Элэг бүтэн Монгол хөтөлбөр	40,016.5	4,563.5	35,453.0	11.4
1.4	83601-Нэмэлт Олон улсын байгууллагаас олгосон санхүүжилт	8,638,419.1	5,190,673.0	3,448,170.2	60.1
1.5	83603-Нэмэлт Дээд шатны төсвөөс хуваарилсан	29,764,829.8	26,816,056.1	2,948,773.7	90.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

1.Төвийн орон тооны цомхотголын талаар:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар төвийн орон тоо, ажилтнуудын үндсэн

цалин хөлсийг баталсан. Тус тушаалын нэгдүгээр хавсралтаар орон тоо бүтцийг 800 ажилтантай баталсныг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/339 дугаар тушаалын дагуу тус төвийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/179 дугаар “Төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалаар 732 орон тоотой байхаар баталж, 8.5 хувиар буюу 68 ажилтнаар орон тоог цомхотгосон байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн А/179 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны зардлыг 8.0 мянган төгрөг, унааны зардалыг 2.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож тайлант хугацаанд 843,065.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон байна.

3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:

Глобал сан болон Австрали Мурдок төслийн санхүүжилтээр 8 их эмчийн гадаад албан томилолтын зардалд 69,752.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

- Глобал сангийн санхүүжилт 20,253.6 мянган төгрөгөөр эрдэм шинжилгээний 26 дахь удаагийн хуралд 3 их эмч, Канад улсын олон улсын хуралд 25,082.9 мянган төгрөг зарцуулж, 2 эмч оролцож, Монгол улсад хийгдсэн сүрьеэгийн чиглэлийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байна.
- Австрали мурок төслийн санхүүжилт 24,415.8 мянган төгрөгөөр Малайз улсад зохион байгуулагдсан хуралд 3 их эмч оролцож “КОВИД-19-ийн вакцины (Pfizer-BioNTech) стандарт болон хагас тунгийн нэмэлт дархлаажуулалтын дараах дархлаа тогтоц, аюулгүй байдал, хариу урвалыг үнэлэх эмнэл зүйн судалгаа”-ны дүнг Олон улсын хуралд хэлэлцүүлж, уг судалгааны ажлын илтгэл нь 1 дүгээр байр эзэлсэн байна.

4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Глобал сангийн дэмжлэгтэй Дархлалын олдмол хомсдол, Сүрьеэгийн төсөл, Дэлхийн банк Азийн хөгжлийн сан, Даян дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан зэрэг байгууллагуудын дэмжлэгтэй зохион байгуулж, сургалтын зардал, урамшуулал, хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээнд 1,166,519.6 мянган төгрөгийг зарцуулж, халдварт өвчний сэргийлэлт, мэдлэг мэдээлэл, хяналтыг дээшлүүлсэн байна.

Агьбар, Төв түшиг, Ногоон дөл ХХК-тай Улаан бурхан өвчний талаарх иргэдэд мэдлэг олгох, мэдээлэл сурталчилгаанд бараа үйлчилгээний бусад зардлаас 45,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад хандив тусламжаар 12 төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 5 төсөл хэрэгжиж дууссан, 7 төсөл үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц / хувь/	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	2024-2025	Орон нутаг сургалт, дэмжлэг хяналт хэрэгжүүлсэн Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас сэргийлэх бэлэн байдал, арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэсэн	100	1,823,877.9	2,096,653.9
2	Глобал сангийн төсөл	2024-2026	Монгол улсын ДОХ, Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, Тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоог бэхжүүлэх, Орон нутагт сургалт, дэмжлэг хяналт хэрэгжүүлсэн	85	2,080,904.5	2,239,058.0
3	НҮБ-ын хүүхдийн сангийн төсөл	2024-2025	Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг улсын хэмжээнд нэвтрүүлэх Улаан бурхан, хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтаар Дорнод, Сүхбаатар аймгуудад дэмжлэгт хяналтыг хийж зөвлөмж өгсөн	100	77,200.5	234,310.9
4	Даян дэлхий ЭМБ төсөл	2024-2025	Улирлын томууны вакцины мэдлэг хандлагыг судлах судалгаа хийх, эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн сургалт, сурталчилгааг хийсэн	100	93,013.7	151,519.6
5	Дэлхийн банк төсөл	2024-2025	Аюултай хог хаягдлын менежментийн үндсэн зорилго болох хог хаягдлын хүний эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл, аюултай хог хаягдлын хэмжээг бууруулсан	100	32,906.6	38,138.0
6	БНХАУ	2025-2026	Архаг Д гепатиттай өвчтөнүүдэд тарилгаар хийх гепатитын зэрэгцээ бүлэгт санамсаргүй түүвэрлэлттэй нууцлалгүй эмнэл зүйг нэвтрүүлэх	88	167,445.2	148,775.9
7	БНСАУ	2025-2026	Монголын сүрьеэгийн оношилгоог хиймэл оюун ухаанд суурилуулах технологийг ашиглаж, үр нөлөөг сайжруулах	85	79,828.5	72,841.1
8	АШУУИС	2025-2026	Эрсдэлд бүлгийн хүн амын дунд улирлын томууны эсрэг вакцины талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх	80	35,151.6	16,000.0
9	Эрүүл мэндийн хөгжлийн төв	2025-2026	Төгсөлтийн дараах сургалт	85	26,163.0	19,500.0
10	Эрүүл мэндийн яам	2025-2026	Төсөл хэрэгжүүлэх	-	58,337.5	-
11	Австралийн Мурдокын хүүхдийн судалгааны төвийн төсөл	2023-2026	Ковид-19 вакцины стандарт болон хагас тунгийн нэмэлт дархлаажуулалтын дараах дархлаа тогтож, аюулгүй байдлын хариу урвалыг үнэлэх эмнэл зүйн судалгаа хэрэгжүүлэх	100	-	173,875.6
12	Элэг бүтэн Монгол хөтөлбөр	2023-2026	Гепатит В,Д, Вирусд өвчтөнүүдэд тусламж үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлэх	20	-	4,563.5
Нийт дүн					4,474,829.1	5,195,236.5

Жилийн эцсийн байдлаар 80.0-100.0 хувийн хэрэгжилттэй 10 төсөл, 50.0 хувиас доош хэрэгжилттэй 2 төсөл байна. Тухайлбал: Монгол Улсын засгийн газраас Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд Гепатит В, Д Вируст өвчтөнүүдэд тусламж

үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгжих хугацаа дуусаагүй хэрэгжилт 20.0 хувьтай байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 19,787,581.9 мянган төгрөгийн 41 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, баталсан. Үүнээс 18,067,869.8 мянган төгрөгийн 13 багц бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 1,319,442.2 мянган төгрөгийн 27 бараа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар, 400,269.9 мянган төгрөгийн 1 бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээгээр худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 11,927,038.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж, хангамж, аж ахуйн материал худалдан авахад 3,389,879.3 мянган төгрөг, нийт 15,316,917.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, улирлын томууны эсрэг вакцин, цэвэрлэгээний материал, өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, вакцин, био бэлдмэл, улаан бурхан өвчин дэгдсэнтэй холбогдуулан улаан бурхан өвчнөөс сэргийлэх урвалж, оношлуур, хүүхдийн тасгийн урсгал засварын ажил, олон эмд тэсвэртэй сүрьеэгийн тасагт механик агааржуулалтын системийн засвар үйлчилгээ зэрэг бараа, ажил үйлчилгээг 13,487,867.7 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулалтаар, 670,280.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, цахим дэлгүүрээс 1,158,769.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг тус тус худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төвийн үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримт бүрдүүлэлтийг хангах, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшууллыг зөв тооцоолох, ашиглалтын хугацаа дууссан бара материал болон биетээр байхгүй бараа материалын асуудлыг шийдэх, шатахуун зарцуулалтыг нормын дагуу тооцож, тооцоо бодох, байгууллагын дансанд бүртгэлэй хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах зэрэгтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Гантөмөр, туслах аудитор З.Мандах нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ж.Бямбажав, дараагийн шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундманхайдай аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1-1/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 116,035,507.5 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 580,177.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд батлагдсан төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 588,052.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 334,147,368.7 мянган төгрөг, норматив зардлыг 2,483,416.4 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 1,521,125.3 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 496,292.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 589,258.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,823,471.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 606,371.5 мянган төгрөгийн 28 гүйлгээг мэдээлээгүй, 3.217,099.9 мянган төгрөгийн 384 орлого, зарлагын гүйлгээ болон худалдан авалтын төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, өр төлбөр данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 74,556.4 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,196.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 26,090,913.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 465,758.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн нь 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	14,196.3	2	14,196.3	100.0
Албан шаардлага	2	26,090,913.5	2	26,090,913.5	100.0
Зөвлөмж	2	465,758.3	2	465,758.3	100.0
Нийт дүн	6	26,570,868.1	6	26,570,868.1	100.0

Тус төв нь 2021-2022 онуудад Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй хуваарилсан 3,265,623.8 мянган төгрөгийн хугацаа дууссан оношлуур, урвалжийг нотлох баримтгүйгээр устгасан албан шаардлагад дараагийн шийдэл сонгож хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь эцэслэн шийдвэр гаргаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид санхүүгийн тайлангийн маягыг шинэчлэх;
2. Бараа материалын дансанд бүртгэлтэй 1,128,379.9 мянган төгрөгийн оношлуурын ашиглалтын хугацаа дууссаныг шийдвэрлэсэн байдал;
3. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж улсын төсөвт төвлөрүүлсэн эсэх, Эрүүл мэндийн яамнаас хуваарилан олгосон иж бүрэн тоноглолтой 2 авто машины ашиглалт, хамгаалалтын байдлыг дахин хянах зэрэг асуудалд дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 74,556.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 74,556.4 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан. Үүнд:

- Санхүү байдлын тайлангийн өр төлбөр дансны эхний үлдэгдлийг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 512.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 65,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 5,534.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Аяга тавгийн цуглуулгыг 956.9 мянган төгрөгийн худалдан авч орлогоор бүртгээгүй;
- Ажилчдаас авах 2,289.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулахдаа суутган тооцоо хийгээгүй, цалингийн зардал дансыг бууруулж буруу бичилт хийсэн;
- Хувь хүмүүсээс авах 262.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулахдаа аж ахуйн материалын зардлыг бууруулж буруу бичилт хийсэн.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 733,116.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 13,238.4 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 639,273.4 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 80,605.1 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 733,116.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 152,939.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 5 эмч, албан хаагчдад 4,266.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д “хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Т өрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгож журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7-д “хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан тушаалтанд үр дүнгийн урамшуулал олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын архивын арга зүйч гэсэн нэг ажилтанд 1,535.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*үнэн зөв байх*”, 20.2.5-т “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын нөхөн олговор, цалин хөлс давхардуулан олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Эмнэлгийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоонд байхгүй дотоод засалч, мужаан гэсэн албан тушаалуудад хавсран ажилласны нэмэгдэл цалинд 2,564.8 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т “*ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “*батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тоонд байхгүй албан тушаалд хавсран ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Тус төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Анхбаярт ур чадварын нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, сар бүр 25 хувиар тооцож ур чадварын нэмэгдэлд нийт 3,832.5 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*үнэн зөв байх*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 6.6.2-д “*төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх*”, 16 дугаар зүйлийн 16.5.9-д “*дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох*” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэргүй ур чадварын нэмэгдэл бодож олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5. Тайлант хугацаанд шатахуун зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, шатахууны тооцоог бодоогүй, замын хуудсаар баталгаажаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй 1,038.9 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*Үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.5-д “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг*

баримт хүчин төгөлдөр болно”, 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтаар нотлогдохгүй шатахуун зарцуулсан зөрчлийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчтай ээлжийн амралтын 2,952.2 мянган төгрөгийн тооцоог хийж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3-д "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ээлжийн амралтын эцсийн тооцоог хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад Халдварт өвчин судлалын үндэсний төв үйл ажиллагаагаа явуулж байгаа эзэмшлийн газрыг 62 м.кв-аар буюу 2,007.6 мянган төгрөгөөр илүү тусгасан мөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлалтай 01110-22-00003-19 дугаар гэрээтэй 14,997 м.кв газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Бараа материалын дансанд бүртгэлтэй өмнөх онд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 619,765.0 мянган төгрөгийн оношлуур агуулахад биетээр оршин байхгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас хүлээж аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Агуулахад биетээр оршин байхгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас оношлуурыг хүлээж аваагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлж, хуулийн байгууллагад шилжүүлэх

4. Жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тооцоо нийлсэн актаас 3,006.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар

зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг дутуу тайлагнасан зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

5. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн даргын 2025 оны А/103 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, аудитын зөрчилгүй дүгнэлт авч сайн дүгнэгдэж 95 оноо буюу А үнэлгээгээр үнэлэгдсэн үндэслэлээр санхүүгийн 8 ажилтанд нийт 11,542.0 мянган төгрөгийн урамшууллыг ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан мөнгөн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Мон жаргалант ХХК-тай байгуулсан цар тахлын үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх сургалтын гэрээний 7,871.4 мянган төгрөгийн хоолны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно," гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сургалтын хоолны зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв баталгаажуулан баримт бүрдлийг ханган ажиллаж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Санхүү байдлын тайлан болон үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 1,232.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дансны эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүүг залруулах.

2.2 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1501 нэр төрлийн 10,880,559.6 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагад санал хүргүүлж ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1-д "Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах хугацааг, шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

2.3 Илрүүлэлт:

Байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 9,941.6 мянган төгрөгийн үнэтэй, ажилчдын 12 айлын орон сууц болон цэцэрлэгийн 2 байрыг хувь хүний нэр дээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх болон газар эзэмших эрхийн гэрчилгээтэй бөгөөд үл хөдлөх хөрөнгүүдийн маргаантай асуудлыг шийдвэрлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг уг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлагнана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй ажилчдын 12 айлын орон сууц болон цэцэрлэгийн 2 байрыг хувь хүний нэр дээр шилжих эсэх асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээг авах.

3. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тус эмнэлэг нь 2025 оны 4 болон 11 дүгээр саруудад цалин, хөлсний зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 12,561.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1--д "энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн-гишүүн иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилтнуудын цалин, хөлсийг дутуу тайлагнасан тооцоог хийж, баталгаажуулах.

3.2 Илрүүлэлт:

Батлагдсан цалингийн зардлаас 41,348.6 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ангилал зөрчиж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах" -тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зардлын ангиллыг бүртгэлд үнэн зөв тусгах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

4. Татварын тайлантай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын 2,339.5 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд суутгасан албан татварын дүнг үнэн зөв бүртгэх, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулах.

5. Худалдан авалтын талаар

5.1 Илрүүлэлт:

Тэгш анар компаниас гэрээний үнийн дүнгээс 5,310.0 мянган төгрөгөөр эм, эмнэлгийн хэрэгсэл /Эссенциаль, уян зүүний наалт/-ийг илүү худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 46 дугаар зүйлийн 46.1.5-д энэ хуулийн 7.6-д "зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан

авах ажиллагааг эхлүүлэх”, 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг гэрээний дагуу худалдан ав байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүү байдлын тайлангийн өглөгийн дансны эхний үлдэгдлийг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 512.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.	1	512.8			1	512.8	1	512.8				
2	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 65,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан байна.	1	65,000.0			1	65,000.0	1	65,000.0				
3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 5,534.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	5,534.0			1	5,534.0	1	5,534.0				
4	Дархлаажуулалтын жендерийн асуудлууд сургалтад 956.9 мянган төгрөгийн аяга тавгийн цуглуулгыг худалдан авч ашиглахдаа бараа материалын дансанд орлогоор бүртгээгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	1	956.9			1	956.9	1	956.9				
5	Ажилчдаас авах 2,289.8 мянган төгрөгийн авлагыг хаахдаа суутган тооцоогүй цалингийн зардал дансыг бууруулах бичилт хийсэн	1	2,289.8			1	2,289.8	1	2,289.8				
6	Хувь хүмүүсээс авах 262.9 мянган төгрөгийн авлагыг хаахдаа аж ахуйн материалын зардлыг бууруулж бичилт хийсэн.	1	262.9			1	262.9	1	262.9				
	Дүн	6	74,556.4			6	74,556.4	6	74,556.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Сахилгын шийтгэлтэй 5 эмч, албан хаагчдад сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 4,266.6 мянган төгрөгийн улирлын ажлын мөнгөн урамшуулал олгосон байна	1	4,266.6	1	4,266.6								
2	Архивын арга зүйч Н.Отгонжаргалд ээлжийн амралт, цалин хөлс давхардуулан олгосон байна	1	1,535.6	1	1,535.6								
3	Эмнэлгийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоонд батлагдаагүй дотоод засалч, мужааны ажилд хавсран ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгосон байна	1	2,564.8	1	2,564.8								
4	Нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан хууль тогтоомжид заагдаагүй балансын урамшууллыг цалингийн сангаас олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна	1	11,542.0			1	11,542.0						
5	ЭМС-ын 2024 оны Б/70 дугаар тушаалаар Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон ажилтад ур чадварын нэмэгдэл 25 хувийг дээд газрын тушаал, шийдвэргүйгээр илүү тооцож олгосон байна	1	3,832.5	1	3,832.5								
6	Тайлант хугацааны шатахуун зарцуулалтын тайланг шалгахад Замын хуудсыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүй, шатахуун зарцуулсан байна.	1	1,038.8	1	1,038.8								
7	Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ээлжийн амралтын тооцоог хийж тайлагнаагүй байна	1	2,952.2			1	2,952.2						
8	Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад газрын хэмжээ 62 м.кв-аар илүү, 14,997 м.кв газар данс бүртгэлд байхгүй байна.	1	2,007.5			1	2,007.5						
9	Бараа материалын дансанд 1,128,379.9 мянган төгрөгийн оношлуурын ашиглалтын хугацаа дууссан, 619,765.0 мянган төгрөгийн оношлуур агуулахад байхгүй байна.	1	619,765.0									1	619,765.0

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Тайлант оны 3,006.6 мянган төгрөгөөр 1 газрын тооцоо нийлсэн акт зөрүүтэй байна.	1	3,006.6			1	3,006.6						
11	Санхүү байдлын тайлангийн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 1,232.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дахин үнэлгээний нөөц дахь үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй байна.	1	1,232.1					1	1,232.1				
12	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1501 нэр төрлийн 10,880,559.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлээгүй байна.	1	0.00					1	0.00				
13	Тус эмнэлэг нь 2025 оны 4, 11 дүгээр саруудад эмч, ажилтнуудын цалин, хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд дутуу тайлагнасан	1	12,561.9					1	12,561.9				
14	Батлагдсан цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл ангилал зөрүүтэй зарцуулсан байна	1	41,348.6					1	41,348.6				
15	Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын дүн санхүүгийн тайланд дутуу тайлагнасан	1	2,339.5					1	2,339.5				
16	Мон-жаргалант ХХК-д Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэдэг халдварт өвчний цар тахлын үеийн тусламж үйлчилгээний үйлчилгээ үзүүлэх сургалтын гэрээний хоолны зардлын баримтын бүрдэл дутуу байна.	1	7,871.4					1	7,871.4				
17	Байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 9,941.6 мянган төгрөгийн үнэтэй, ажилчдын 12 айлын орон сууц болон цэцэрлэгийн 2 байрыг ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн 224 тогтоолоор хувь хүний нэр дээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх болон газар эзэмших эрхийн гэрчилгээтэй дээрх үл хөдлөх хөрөнгүүдийн маргаантай асуудлыг хууль тогтоомжид нийцүүлж шийдвэрлэх үүрэг өгсөн нь хэрэгжээгүй зөрчилтэй хэвээр байна.	1	9,941.6					1	9,941.6				
18	Худалдан авах ажиллагааны тендерт шалгарсан Тэгш наран компаниас эм, эмнэлгийн хэрэгсэл / Эссенциаль, уян зүүний наалт/ 5,310.0 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн байна.	1	5,310.0					1	5,310.0				
Дүн		18	733,116.9	5	13,238.4	4	19,508.4	8	80,605.1			1	619,765.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" болон "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ"-г мөнгөн хөрөнгийн дансны журнал, харилцах дансны хуулгатай тулгахад 606,371.5 мянган төгрөгийн 28 гүйлгээг мэдээлээгүй, 3.217,099.9 мянган төгрөгийн 384 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн худалдан авалтын төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроосон байна.	1	3,823,471.5	1	3,823,471.5		
Дүн		1	3,823,471.5	1	3,823,471.5		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2006 онь 02 сарын 25 өдөр

Дугаар 92/20150135

Улаанбаатар хот

СЯТ-2026/269/НА-СТА-ТМЗ

Төлбөрийг барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шатахуун зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, шатахууны тооцоог бодоогүй, замын хуудсаар баталгаажаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй 1,038,870.70 *Инэг сая гучин найман мянга найман зуун далан төгрөг далан мөнгө* төгрөгийг шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8.Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нягтлан бодогч Н.Одгэрэлээр анхан шатны баримтаар нотлогдохгүй шатахуун зарцуулсан 1,038,870.70 *Инэг сая гучин найман мянга найман зуун далан төгрөг далан мөнгө* төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 93/АД/50185

Улаанбаатар хот

САГ-2026/269/МА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Анхбаярт ур чадварын нэмэгдлийг сар бүр 25.0 хувиар тооцож 3,832,500.00 /гурван сая найман зуун гучин хоёр мянган таван зуу/ төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн тушаал шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.6.2-д "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.9-д "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хүний нөөцийн албаны дарга Ж.Баярсайханаар тушаал, шийдвэргүй бодож олгосон ур чадварын нэмэгдэл хөлс 3,832,500.00 /гурван сая найман зуун гучин хоёр мянган таван зуун/ төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 84/А0150185

Улаанбаатар хот

СМН-2026/209/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмнэлгийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоонд байхгүй дотоод засалч, мужаан гэсэн албан тушаалуудад 2,564,848.56 /хоёр сая таван зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин найман төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т "ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хүний нөөцийн албаны дарга Ж.Баярсайханаар орон тоонд байхгүй албан тушаалд хавсран ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгосон 2,564,848.56 /хоёр сая таван зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин найман төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 95/20150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын архивын арга зүйчид 1,535,622.10 /нэг сая таван зуун гучин таван мянга зургаан зуун хорин хоёр төгрөг арван мөнгө/ төгрөгийн ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хүний нөөцийн албаны дарга Ж.Барсайханаар илүү тооцож олгосон цалин 1,535,622.10 /нэг сая таван зуун гучин таван мянга зургаан зуун хорин хоёр төгрөг арван мөнгө/ төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 96/А0150185

Улаанбаатар хот

САГ- 2026/269/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлтэй 5 ажилтанд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 4,266,600.00 *Идөрвөн сая хоёр зуун жаран зургаан мянга зургаан зуун* төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "хөдөлмөрийн сахилгын шийтгэл нэгдүүлснаас хойш нэг жил өнгөрөөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгож журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хүний нөөцийн албаны дарга Ж.Баярсайханаар сахилгын шийтгэлтэй албан хаагчид олгосон 4,266,600.00 *Идөрвөн сая хоёр зуун жаран зургаан мянга зургаан зуун* төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 462/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 606,371,523.32 /зургаан зуун зургаан сая гурван зуун далан нэвэн мянган таван зуун хорин гурван төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн 28 гүйлгээг мэдээлээгүй, мөн 3.217,099.977.00 /гурван тэрбум хоёр зуун арван долоон сая ерэн есөн мянга есөн зуун далан долоо/ төгрөгийн 384 орлого, зарлагын гүйлгээ болон худалдан авалтын төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд системд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 463/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тооцоо нийлсэн актаас 3,006,609.39 /гурван сая зургаан мянга зургаан зуун есөн төгрөг гучин есөн мөнгө/ төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 3,006,609.39 /гурван сая зургаан мянга зургаан зуун есөн төгрөг гучин есөн мөнгө/ төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 464/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн даргын 2025 оны А/103 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, аудитын зөрчилгүй дүгнэлт авч сайн дүгнэгдэж 95 оноо буюу А үнэлгээгээр үнэлэгдсэн үндэслэлээр санхүүгийн 8 ажилтанд нийт 11,542,000.00 *Арван нэгэн сая таван зуун дөчин хоёр мянган* төгрөгийн мөнгөн урамшууллыг, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "*Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна*", 51.1.4-д "*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*", 15.1.3-т "*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "*Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно*", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-т "*байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, мөнгөн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 465/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд бүртгэлтэй өмнөх онд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 619,765,000.00 /Зургаан зуун арван есөн сая долоон зуун жаран таван мянга/ төгрөгийн оношлуур агуулахад биетээр байхгүй, бэлтгэн нийлүүлэгчээс хүлээж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэсэн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас оношлуурыг хүлээж аваагүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ӨРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 466/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/КА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад Халдварт өвчин судлалын үндэсний төв үйл ажиллагаагаа явуулж байгаа эзэмшлийн газрыг 62 м.кв-аар буюу 2,007,560.00 /хоёр сая долоон мянга таван зуун жаран/ төгрөгөөр илүү тусгасан мөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлалтай 01110-22-00003-19 дугаар гэрээтэй 14,997 м.кв газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Биет бус хөрөнгө 11.2-т "Биет бус хөрөнгөнд ...газар эзэмших эрх, бусад биет бус хөрөнгө зэрэг хамаарна.", Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д "Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР -
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 467/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/269/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажлаас чөлөөлөгдсөн 2 албан тушаалтан 2,952,215.50 /хоёр сая есөн зуун тавин хоёр мянга хоёр зуун арван таван төгрөг тавин мөнгө/ төгрөгийн ээлжийн амралтын эцсийн тооцоог хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3."Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан ээлжийн амралтын эцсийн тооцоог хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал /С.Энхболд/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ж.БЯМБАЖАВ

